



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/354

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 38.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 23/14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 7 дугаарт батлагдсан Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардлаас Тарагт сумын Засаг даргын Тамгын газарт автомашин авах зардалд 95,000,000 төгрөг, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт автомашин авах зардалд 95,000,000 төгрөг, нийт 190,000,000 (нэг зуун ерэн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газарт даалгасугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Хөрөнгө зарцуулах тухай" А/252 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0786

D:My Doc. Zahiramj. Zasag darga